



Үндэсний геологийн албаны 2024 оны  
 дугаар сарын 09-ны өдрийн дугаартай  
 албан бичгийн 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН “УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НД ҮНДЭСНИЙ  
 ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024 он

№	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			2024 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч /УУХУЯ/	Хамтран хариуцагч /УГА/
				Суурь түвшин /2021 он/	Зорилтот түвшин /2024 он/	Санхүүжүүлсэн хэмжээ /сая.төг/	Санхүүжилт ийн эх үүсвэр			
0	1	2	3	4	5	6	7	8	9	Тайлан
<p>“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД.</p> <p>ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.</p>										
2.2	АХ-4.2.24,МУХТ-ЗҮЧ-4.2.1,ЗГҮАХ-3.2.3	2.2.1.1. Орчин үеийн дэвшилтэд технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх.	Нислэгт хамрагдсан талбай	0	20%	15,107.27	Улсын төсөв			Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизик-2024" төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, шалгарсан "Геологийн судалгаа-шинжилгээний төв" ТӨҮГ-тай 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, төслийн ажлыг шинээр эхлүүлсэн.

								<p>Төслийн хүрээнд 2024 онд Агаарын геофизикийн "Tempres" цахилгаан соронзон болон нэмэлтээр нэгэн зэрэг хэмжих багажууд болох Scintrex CS-3 соронзон орны, RS радиометрийн, iCORUS хүндийн хүчний төхөөрөмжүүдээр 67829 км2 талбайн геофизикийн цогц системээр хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн.</p>
2.2	<p>АХ-4.2.24,МУХТЗ ҮЧ-4.2.1,3ГҮАХ-3.2.5</p>	<p>2.2.1.2. Газрын элемент өндөр технологийн эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх</p>	<p>Талбайн хэмжээ, км2</p>	<p>2585.21</p>	<p>12,013.74</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй сэдэвчилсэн 4 төслийн 2024 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэл, дүгнэлт, тушаалын төслүүдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам -нд хүргүүлсэн бөгөөд үргэлжлэн хэрэгжүүлж байгаа. Үүнээс 2024 онд үр дүнгийн суурин боловсруулалтын ажилтай Өндөр технологийн түүхий эд-2-2022, Эрэл үнэлгээ-4-2022, БМШАМ-2022 зэрэг нийт 3 төсөлд УГА-тай хамтран тайлангийн шуурхай хяналт хийсэн.</p> <p>Өндөр технологийн түүхий эд-2-2022, Эрэл үнэлгээ-4-2022, БМШАМ-2022, Мета алт-500 төслүүдээс ирүүлсэн сар бүрийн гүйцэтгэлийг хяналт хийж, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа Өндөр технологийн түүхий эд-2-2022, Эрэл үнэлгээ-4-2022, БМШАМ-2022, Мета алт-500 зэрэг судалгааны ажлаар 2024 оны жилийн эцсийн байдлаар</p>	

								<p>тогтоогдсон үр дүнг урьдчилсан байдлаар дурдвал:</p> <p><b>1. Демон инженеринг” ХХК-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-II</b> төслийн нарийвчилсан эрлийн ажлаар ГХЭ-ийн Мушгиа худгийн хүдрийн дүүрэг, бүсэд газрын ховрын хэтийн төлөвтэй талбайнууд нэлээд тогтоогдож, Дундговийн болон Өмнөд Хэнтийн бүсэд газрын ховор элементийн цэгүүд илэрсэн. Хэтийн төлөв бүхий ГХЭ-ийн Өлгий хийд, Нарийн уулын, ГХЭ- барит-целестин-стронцианитын хүдэржилт бүхий Баянхошуу илрэл, Эрлийн талбай-1 /Мушгиа худаг-Зүүн/-д ялгасан ГХЭ-ийн Хар толгой, Жоншит, Бор толгойн талбайнууд, ГХЭ-ийн Дэлгэрхангай бүлэг эрдэсэжсэн цэгүүд, Литийн Хэцүү тээг болон Тээг уулын болон Дөрвөн дэргтийн талбай, Зос уул, Урт гозгор, Бууралхангайн илрэлүүд, Талст графитын Хөх хад-1 ба 2 бүлэг илрэлүүд дээр 2024 оны хээрийн нэмэлт ажлууд хийгдсэн.</p> <p><b>2. Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга сумдын нутагт “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-ын гүйцэтгэж буй Эрэл үнэлгээ- 4</b> төслийн ажлын эцсийн суурин боловсруулалтыг 2024.12.31-нд дуусна. Төслийн ажлын товч үр дүн: Задгай ам Аu; Хавхааст худаг Аu-Cu; Хавтгайн цахирын нүүрс, Ширдэгт- Төв</p>
--	--	--	--	--	--	--	--	--

									<p>илрэлүүдийг ялгаж, нарийвчилсан эрлийн ажил хийсэн.</p> <p>Задгай ам илрэлийн кварц-пирит-малахитат судал, судланцарын бүсэд Au-0.01г/т-16.4г/т, Ag-1-7г/т, Cu-0.04%. Анхдагч геохимийн 366ш сорьцод Au 0.1г/т агуулгатай хоёр сарнилын хүрээ тогтоогдсон. Хавхааст худаг-Au илрэл, кварц-пирит-халькопиритэт судлын 7 дээжид Au-0.26-6.5 г/т, 3 дээжид Cu-0.6%. Анхдагч геохимийн 347ш сорьцод Au-ны 0.1г/т агуулгатай хоёр сарнилын хүрээ илэрсэн. Дээд юрийн Жаргалант формацийн тунамал хурдаст 0.2-2.5м хүртэл зузаантай хүрэн нүүрсний нимгэн 17 үе илэрсэн. Хавтгайн цахир илрэлийн (130м) нүүрс нь 3325-4960 ккал/кг илчлэгтэй. Нүүрсний таамаг баялгийг 35.6 мян.тонн-оор тооцсон. Ширдэгт (Төв) (Au-Cu(Zn, Pb) ийн илрэл дээр 2 цооног (ShDDH-5, 9) нэмж ерөмдсөн. 2.12 г/т - 18м (58-76м интервалд), максимум - 35.05 г/т (ShDDH-05); 0.53 г/т-32м (77-109м интервалд), максимум -9.32 г/т (ShDDH-05); 0.43 г/т-23м (27-50м интервалд, ShDDH-09) үеүд илэрнэ.</p> <p><b>3. Магнетик сурвей ХХК-ийн гүйцэтгэж буй Мета алт-500</b> төслийн талбайн хэмжээнд ялгасан Тээг толгой, Занги, Замын ам, Сэнжитийн хяр, Зангат, Олон -Овоот, Дэл хайрхан, Шар Ухаа, Овоот, Бор цахир, Эрдэнэ Монгол баруун, Хөөврийн цахир, Цагаан хад, Завсрын толгод, Зараат, Ямаат,</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

<p>Завтын хяр уул, Будагт, Улаан хийд талбайг ангилах, 2022-2024 онд цуглуулсан дээж, ялгасан үнэлэх, нэгдсэн таних тэмдэг, төслийн суурь зураг зэрэг суурийн боловсруулалтын ажлууд хийж байна. Ялгасан талбайнуудын далд тогтцыг судлах, цаашдын судалгааны ажлын чиглэлийг гаргах, үнэлгээ өгөх зорилгоор, соронзон зураглал 650 т.км, гамма-спектрометрийн зураглал 200 т.км, TEM 468 ф.ц, АТ-ДГ 125 т.км, АТ-ПД 60 т.км ажлуудын боловсруулалт, тайлагналтын ажил гүйцэтгэж байна. 2700 дээжид Алтны шинжилгээ FAE303, FAA303, ICP14B, ICM40B, ICM90A шинжилгээ, 2500 дээжид хувирлын минералогийн хэмжилт, Стандарт дээж худалдаж авах зэрэг ажил гүйцэтгээд байна. Нийт дээжээс 200 ширхгийг сонгож лабораторийн гадаад хяналт хийлгэхээр өгөөд байна.</p> <p><b>4. БМШАМ-2022</b> төслийн ажлын хүрээнд цуглуулсан дээжинд хийлгэсэн шинжилгээний үр дүнгээр боловсруулалт, сансрын зургийн болон геофизикийн тайлалт хийж, (M-46-52-Б-г хавтгай) Баруунтэрмис уулын, M-46-141-Б-в хавтгайн Тас хайрханы, L-46-4-В-а хавтгайн Ховдын талбайд геологи-структурын зургийг зохиосон. Тектоникийн анхдагч зургууд, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн суурь материалууд, хээрийн судалгааны үр дүн дээр</p>								
---	--	--	--	--	--	--	--	--

								<p>Үндэслэн 1:500000 ба 1:200000-ны масштабын тектоникийн зургийн легенд боловсруулагдан, төслийн талбайн хэмжээнд 1:200000-ны масштабын тектоникийн зураг, 1:500000 масштабын тектоникийн зургийн нэгтгэл, тектоникийн дүүрэгчлэлийн зураг зохиогдож, түүний тайлбар бичиг хийгдсэн. ШАМ-ын зураг суурь материалууд дээр үндэслэн 1:500000-ны масштабын болон 1:200000-ны масштабын шатах ашигт малтмалын зураг зохиосон. Үр дүнгийн тайлангийн тайлбар бичиг хийгдэж байна.</p>
2.2	<p>АХ-4.2.24, МУХТЖҮЧ- 4.2.1, ЗГҮАХ-3.2.4</p>	<p>2.2.1.3.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлнэ.</p>	<p>Цахимжсан мэдээллийн хэмжээ /хувь/</p>	5	25	3,896.86	Улсын төсөв	<p>Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн системийг Үнэмлэхүй нас-1119, Интрузив чулуулаг-3362, Эффузив чулуулаг-360, Палеонтологийн олдвор-3567, Горизонт-61, Стратиграфи /давхарга зүйн сан/-706, Уст цэг /худаг/-8200, Булаг-3100, Илрэл-5418, МонGeoCat/метадата/-4880, Цахим бүтээлийн сан үүсгэх-5833, Шлихийн хүрээ-2966, Цооног-5600, Өрөмдсөн цооног-920, Эрдэсжсэн цэг-201, Чулуун дээж-1039, Шлиф-2893, Аншлиф-330, Идэвхтэй хагарал-301, Гүний хагарал-2350 <b>Нийт 20270</b> мэдээллээр баяжуулж цахим системд оруулсан. Чулуун сангийн агуулахад байгаа ордуудын дээжийг бүртгэх, системд оруулах ажлын хүрээнд нийт 165 ордын чулуун дээж- <b>6904</b>, чөмгөн</p>

									<p>Дээж-776, шлиф-24535, аншлиф-3056, технологийн дээж-6 ширхэг буюу 1973 ширхэг дээжийг бүртгэлжүүлсэн.</p> <p>Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-2165, шлифийн-2700, аншлифийн-52 ширхэг фото зургийг авч мэдээллийн бичвэрийг хийгээд байна. Тайлангийн хавсралт материалаас 17422 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийн, оруулсан.</p> <p>Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд 10255 тайлан, 19376 хадгаламжийн нэгжийн хэмжээнд 7 дансны мэдээлэл боловсруулж мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулсан. Нийт цахимжсан мэдээлэл 27 хувьд хүрсэн.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2024 оны 12 дугаар сарын 09.